



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 1/478

Арвайхээр

Тендерийг хүчингүй болгож, шууд
гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 81 дүгээр дүгнэлтийн дагуу хуралдаанаараа Эрүүл мэндийн салбарын их засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай/ ажлын 4 дүгээр багц Сумдын Эрүүл мэндийн төвийг гал тогооны тоног төхөөрөмжөөр хангах ажлыг хүчингүй болгож шууд гэрээ байгуулсугай.
2. Дээрх хүчингүй болсон багцын техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэн үнийн харьцуулалт хийж, гэрээ байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.
3. Шууд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100824

D:My Doc. Zahiramj. Zasag darga